

**“ХҮНСНИЙ НОГОО” ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦАД
ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

(2018 оны жилийн эцсийн байдлаар, явцын тайлан)

2019 оны 03 дугаар сарын 30-ны өдөр

№	Хөтөлбөрийн агуулга		Гүйцэтгэл		
1.	“Хүнсний ногоо” үндэсний хөтөлбөр Засгийн газрын 2017 оны 278 дугаар тогтоол		Зорилго: Өрхийн тариалан эрхлэгч болон хүнсний ногооны төрөлжсөн аж ахуйн нэгж, хоршоог дэмжих замаар хүнсний ногооны үйлдвэрлэлийг хөгжүүлж, дотоодын хэрэгцээгээ жилийн турш тогтвортой хангахад зорилго оршино.		
2.	Санхүүжилтийн үүсвэр	эх	Улс, орон нутгийн төсөв, олон улсын байгууллагын санхүүжилт		
3.	Хэрэгжүүлэгч байгууллага/ нийт хугацаа	хэрэгжих	Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага: Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам Хугацаа: 2018-2022 он Хамтран хэрэгжүүлэгч байгууллага: Аймаг, нийслэлийн ХХААГ, ТЭДС, Гадаадын төслүүд		
	Төсөл, хөтөлбөрийн зорилтууд		<p>Зорилт 1. Хамгаалагдсан хөрсний тариаланг дэмжиж, таримлын нэр төрлийг олшруулж, нэгж талбайгаас авах ургацыг нэмэгдүүлэн өвөл, хаврын улиралд хүн амыг шинэ ургацын хүнсний ногоогоор тогтвортой хангаж, импортын хамаарлыг бууруулах;</p> <p>Зорилт 2. Дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх замаар хүнсний ногооны үйлдвэрлэлийг эрчимжүүлж, усалгаатай тариалангийн хэмжээ, агуулах, зоорийн багтаамжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн хувийн хөрөнгө оруулалтыг урамшуулах, шууд худалдааны сүлжээ, төрөлжсөн захыг дэмжин хөгжүүлэх;</p> <p>Зорилт 3. Хүнсний ногооны үр үйлдвэрлэлийг дэмжиж, ирээдүйтэй болон нутагшсан сортыг туршиж, үйлдвэрлэлд нэвтрүүлэн үрийн чанарыг сайжруулж, хангамжийг нэмэгдүүлэх;</p> <p>Зорилт 4. Хүнсний ногооны үйлдвэрлэл эрхлэгчдийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, мэргэжилтэй ажилтан бэлтгэх, давтан сургах, мэдээллээр хангах замаар хүний нөөцийн чадавхийг сайжруулах.</p>		
5.	Үзүүлэлт	Төсөв (Нийт шаардагдах зардал)	Тухайн жилийн төсөв: Улсын төсвөөс 1000.0 сая төгрөг, Орон нутгийн төсвөөс 1500.0 сая төгрөг, ШХА-ын буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж буй “Монгол ногоо” төслөөс 2.47 тэрбум төгрөг, Нийт 4.97 тэрбум төгрөг,		
		Үүнд:	Төсөв (он)	Гүйцэтгэл	Хувь
	Төсөл, хөтөлбөрийн зорилт:		Арга хэмжээний биелэлт		
6.	“Хамгаалагдсан хөрсний тариаланг дэмжиж, таримлын нэр төрлийг олшруулж, нэгж талбайгаас авах ургацыг нэмэгдүүлэн өвөл, хаврын улиралд хүн амыг шинэ ургацын хүнсний ногоогоор тогтвортой хангаж, импортын хамаарлыг		<p><i>1.1. Өвлийн хүлэмжийн аж ахуйг байгуулахад хөнгөлөлттэй нөхцөлөөр зээлийн дэмжлэг үзүүлж, хот суурингийн хүн амыг жилийн турш шинэ ургацын ногоогоор хангах;</i></p> <p>Өвлийн хүлэмжийн цогцолбор аж ахуй байгуулах төслийг боловсруулж БНСУ, Турк, БНХАУ-ын хөнгөлөлттэй зээлд хамруулахаар Засгийн газарт хүргүүлэв. АХБ-ны “ХАА, хөдөөгийн төслийн нэмэлт санхүүжилт” төслийн хүрээнд хүлэмжийн аж ахуй байгуулахад 7 жилийн хугацаатай зээлийн эх үүсвэр бий болсон тул төслийн санал авч, банкнууд судалгаа хийж байна.</p> <p>20 га талбайд “Өвлийн хүлэмжийн аж ахуй байгуулах” төсөл, жил бүрийн 11 дүгээр сарын 01-нээс 05 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл хугацаанд оройн 22 цагаас өглөөний 06 цагийн хооронд</p>		

<p>бууруулах” 1-р зорилтын хүрээнд:</p>	<p>өвлийн хүлэмжийн ахуйд хэрэглэсэн цахилгааны төлбөрөөс 1 м² талбайд 0.762 кв/цаг-аар тооцож 100 хувь чөлөөлөх тухай Засгийн газрын 2018 оны 324 дүгээр тогтоолыг батлуулсан.</p> <p style="text-align: right;">ХШҮ-40</p> <p><i>1.2. Орон нутагт зуны нийлэг хальсан хүлэмж байгуулахад зориулж хөнгөлөлттэй нөхцөлөөр дэмжлэг үзүүлж, таримлын нэр төрлийг нэмэгдүүлэх;</i></p> <p>Улсын төсвийн хөрөнгөөр 32 м² талбай бүхий 160 ширхэг нийлэг хальсан хүлэмж нийлүүлэх тендер шалгаруулж, ХХААХҮЯ-ны төрийн нарийн бичгийн даргын А/600 дугаар тушаалаар гэрээ байгуулан зуны хүлэмжийн үйлдвэрлэлийг 5120 м² талбайгаар нэмэгдүүлсэн.</p> <p>2018 онд Жижиг, дунд үйлдвэрлэл хөгжүүлэх сангаас 3 га талбайд өвлийн хүлэмж байгуулах 12 иргэн, аж ахуйн нэгжид 4.2 тэрбум төгрөгийн зээлийн дэмжлэгт хамрагдсан. Ингэснээр 2018 онд хүлэмжийн талбай 91.6 га болж 5750 тонн ургац хураан авсан байна. Энэ нь 2016 оноос хүлэмжийн талбай 15.6 га талбай, ургац 610 тн-оор нэмэгдэв.</p> <p>Орон нутгийн төсвөөр Өмнөговь аймаг 318.4 сая төгрөгөөр хүлэмжинд ашиглах боломжтой шинэ техник технологи нэвтрүүлэх, туршилт, судалгаа, үйлдвэрлэлийн зориулалттай 10 ширхэг 6*50 хэмжээтэй хүлэмжийг барьж, “Хүлэмжийн цогцолбор аж ахуйг” хөгжүүлэхэд шаардлагатай инженерийн хийцтэй худаг болон талбайн усалгааны системийг шийдэхээр техник хэрэгсэл суурилуулсан. Орон нутгийн хөрөнгө оруулалтаар 6*20м –н 22 ширхэг нийлэг хальсан хүлэмжийг 60 хувийн хөнгөлөлттэй нөхцлөөр газар тариалан эрхлэгчдэд олгосон.</p> <p>Хүлэмжинд 10 нэр төрлийн таримал тариалж 2017 оныхоос 4 нэр төрлөөр нэмэгдэв.</p> <p style="text-align: right;">ХШҮ-100</p> <p><i>1.3. Хүлэмжинд мөөг, ашигт таримал, гүзээлзгэнэ тариалахыг дэмжиж, гидропоник болон босоо тавиурт усан орчинд ногоо ургуулах дэвшилтэт технологийг нэвтрүүлж, нэгжийн ургацыг нэмэгдүүлэх;</i></p> <p>Монгол ногоо төлийн хүрээнд 2018 онд туршиж нэвтрүүлсэн нэг шинэлэг технологи бол нийлэг хальсан хүлэмжний автомат агааржуулалтын систем юм. Температурын мэдрэгч бүхий автомат горимоор нээгдэж, хаагдах агааржуулалтын системийг туршиж нэвтрүүлсэн. Хүлэмжинд мөөг, эмийн ургамал, навчит ногоо, лооль хэмх, гүзээлзгэнэ, цэцэг, суулгац үрслэг үржүүлж 207.5 га талбайгаас 2319 тн ургац хураан авсан байна.Төгс ургац ХХК Чингис бондын зээлийн хөрөнгө оруулалтаар 10,000 м² талбай бүхий орчин үеийн гидропоник хүлэмжийн аж ахуйг 2014 онд ашиглалтад оруулсан ба 2018 онд нэмж 10,000 м² талбайг ашиглалтад оруулахад бэлэн болсон.</p> <p style="text-align: right;">ХШҮ-40</p> <p><i>1.4. Хөрсний үржил шимийг сайжруулах, нөхөн сэргээх, ургацын чанар, тоо хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор таримлын ургалтын үеийн био, органик, эрдэс бордоог хэрэглэхэд дэмжлэг үзүүлэх;</i></p> <p>Төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнийн талбайн хөрсний үржил шимийг сайжруулах зорилгоор 123 тн эрдэс бордоог 150.0 сая төгрөгт нийлүүлж, төмс хүнсний ногоо эрхлэгчдэд 50 хувийн хөнгөлөлттэй нөхцөлөөр олгосон. Үүний үр дүнд 410 га талбайн үржил шимийг сайжруулж, нэг га талбайн ургац 10 цн-ээр нэмэгдэх боломж бүрдсэн.</p> <p style="text-align: right;">ХШҮ-100</p>
---	--

		<p><i>1.5. Ургамал хамгааллын цогц арга хэмжээг хэрэгжүүлэх, зохистой дадал, шинэ технологийг нэвтрүүлэх замаар химийн бодисын хэрэглээг бууруулах;</i></p> <p>2018 онд Монгол ногоо төслийн хүрээнд УХЭШХ-тэй хамтран шинээр өвчний эсрэг 4 төрлийн бодис, шавьжны эсрэг 8, биологийн гаралтай өсөлт идэвхижүүлэгч 6, холимог бордоо 4 нэр төрлийг тус, тус туршсан. Талбайн туршилтыг шинээр байгуулагдсан Экстейншин төвүүдийн туршилт, судалгааны талбар дээр Ургамал хамгааллын хүрээлэнгийн эрдэмтдийн арга зүйгээр явуулав. Энэ ажлын үр дүнд 2019 онд Монгол улсад импортлох, ашиглаж болох ургамал хамгааллын бодисын албан ёсны жагсаалтанд дээрх нэр төрлийн хүнсний ногооны пестицид шинээр батлагдах жагсаалтад орсон. Эдгээр бодисууд дандаа бага савалгаатай, өрхийн тариалан, тэр дундаа хүлэмжний хортны эсрэг хэрэглэж болдог бодисууд байгаагаар онцлог юм. Зохистой дадал хэрэгжүүлэхэд Тайланд Улсад үйлдвэрлэсэн перитроид, фосфор-органик, карбамидын бүлгийн пестицидийн үлдэгдэл илрүүлэх оношлуурыг туршиж, нэвтрүүлэхээр боллоо. Өнөөдрийн байдлаар пестицидийн үлдэгдлийг зөвхөн Улаанбаатар хотод байрлах 1-2 төв лабораторт нэг дээжинд өндөр мэдрэгчтэй масс детекторын аргаар 27,000 ₮-өөр хийдэг бол дээрх оношлуурын арга нь нэг дээжийг оношлоход 4,000 ₮ буюу хэд дахин хямд өртөгтэй мөн лабораторийн бус аль ч нөхцөлд хэрэглэж болохоор давуу талтай.</p> <p style="text-align: right;">ХШҮ-40</p> <p><i>1.6. Хүнсний ногооны тариалалт, хураалт, хадгалалтын технологийг хөрс, бордоо, ургамал хамгаалал, сорт, усжуулалт, механикжуулалт, хадгалалт, тээвэрлэлт, бүтээгдэхүүн үйлдвэрлэлтэй хамтад нь авч үзэн цогцоор нь боловсруулж тариалан эрхлэгч иргэн, аж ахуйн нэгжид зөвлөмж болгон хэрэгжүүлэх;</i></p> <p>Хүнсний ногооны техникийн шинэчлэлийн хүрээнд улсын төсвийн 1.7 тэрбум төгрөгийн хөрөнгөөр дунд оврын 19 трактор, хүнсний ногооны 27 иж бүрдэл техник худалдан авснаар 600 га талбайн хүнсний ногооны хөрс боловсруулах, арчлах, хураах ажлыг механикжуулах боломж бүрдүүлэв.</p> <p style="text-align: right;">ХШҮ-40</p> <p><i>1.7. Хүнсний ногоог хатаах, хөлдөөх, хуурайшуулах дэвшилтэт технологийг нутагшуулах, шинэ нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх технологи турших, үйлдвэрлэлд нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх;</i></p> <p>Хүнсний ногоог дахин боловсруулж, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэл бий болгох зорилгоор Монгол ногоо төслөөр 110 сая төгрөгийн цехийн тоног төхөөрөмж болон ажлын байрны засварын дэмжлэгийг нийт 7 анхан шатны хоршоодод үзүүллээ. Дэмжлэгийн хүрээнд тариаланчид чанар, аюулгүй байдал хангасан орон нутгийн брэнд бүтээгдэхүүн үйлдвэрлэж, зах зээлд нийлүүлэх суурь тавигдсан. Цаашид эдгээр хоршоодыг эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд нь үйлдвэрлэсэн нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүнийг дундын хоршооны маркетингийн сувгийг ашиглан зах зээлд гаргана.</p> <p style="text-align: right;">ХШҮ-100</p> <p><i>1.8. Статистикийн албан ёсны мэдээлэлд хүнсний ногоог таримлын нэр төрлөөр оруулж, мэдээллийн нэгдсэн цахим сан бүрдүүлэх.</i></p> <p>Хүнсний ногооны 10 нэр төрлийн тарималаар яамны дотоод мэдээллийг аймгуудаас авч нэгтгэж эхэлсэн. АХБ-аас хэрэгжүүлж буй “Хоршоолсон хэлбэрээр хүнсний ногоо эрхлэх замаар өрхийн</p>
--	--	--

		<p>амьжиргааг сайжруулах” төслийн хүрээнд Увс аймгийн Улаангом сум, Төв аймгийн Борнуур сум, Сэлэнгэ аймгийн Ерөө сум, Дархануул аймгийн Орхон сумын ногоочдод цахим мэдээллийн санг үүсгэж ухаалаг гар утсанд апплекейшн суулгах юм. Төслийн үр дүнг нийт ногоочин өрхүүдэд цаашид түгээх зорилттой. Тариалалт буюу үйлдвэрлэгчээс хэрэглэгч хүртлэх 12 шат бүрийн үе шатны мэдээлэл оруулахаар төсөл боловсруулагдаж байгаа болно.</p> <p style="text-align: right;">ХШҮ-70</p> <p style="text-align: center;">Зорилт 1-ийн биелэлтэд хийсэн ХШҮ-ний дундаж дүн 66.2 хувь</p>
	<p>“Дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх замаар хүнсний ногооны үйлдвэрлэлийг эрчимжүүлж, усалгаатай тариалангийн хэмжээ, агуулах, зоорийн багтаамжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн хувийн хөрөнгө оруулалтыг урамшуулах, шууд худалдааны сүлжээ, төрөлжсөн захыг дэмжин хөгжүүлэх” 2-р зорилтын хүрээнд:</p>	<p><i>2.1. Хүнсний ногоо үйлдвэрлэгчийн захиалгаар бага, дунд оврын трактор, түүнд зориулсан чиргүүл дүүжин машин, мотоблок болон түүнд сольж угсардаг үрлэгч, арчлах, хураах техникийг нийлүүлэх ажлыг зохион байгуулах;</i></p> <p>Улсын төсвийн 334.0 сая төгрөгийн хөрөнгөөр авсан хүнсний ногооны 15 иж бүрдэл техникийг ХХААХҮ-ийн сайдын А-113 дугаар тушаалаар 20.0 хувийн урьдчилгаатай 5 жилийн хугацаатай зээлээр олгохоор шийдвэрлэж, ажлыг зохион байгуулав.</p> <p>Хүнсний ногооны гар үр үрлэгч 230 ширхэгийг тендерээр авч, ХХААХҮ-ийн сайдын А-116 дугаар тушаалаар 20.0 хувийн урьдчилгаатай, 3 жилийн лизингээр олгож байна. Бага оврын техникээр 230 ногоочин хангагдана. Монгол ногоо төслийн хүрээнд ургамал хамгааллын бодис шүршигч 10 ширхэгийг Польш улсаас нийлүүлж Төв, Сэлэнгэ, Ховд, Увс аймгийн хүнсний ногоо эрхлэгчдэд нийлүүллээ. 25 морины хүчин чадалтай бага оврын тракторт зориулсан 4 мөрний цагт 700 м²-талбай тариалах бүтээмжтэй сонгины үрлэгчийг 11 ширхэгийг захиалгаар Сэлэнгэ аймгийн Мандал сумын ногоочин Цогтбаатараар хийлгүүлж үйлдвэрлэл дээр туршсан. Эдгээр тоног төхөөрөмж нь мөн тариаланчдад түрээсийн журмаар үйлчилсэн бөгөөд 1 га талбайд төл сонгино гараар тарихад 1 сая төгрөгийн зардал гардаг бол үрлэгчээр тарихад 150 мянган төгрөг болж байгаа нь эдийн засгийн хувьд их үр өгөөжтэйг дурдан, цаашид олон аймаг сумдын тариаланчид энэхүү үрлэгчийг 2019 онд захиалж хийлгэхээр болоод байна. Хүнсний ногоо үндэсний хөтөлбөрийн хүрээнд дунд оврын трактор, хүнсний ногооны иж бүрдэл техник, үрлэгч зэрэг худалдан авалтын тендер зарлагдан, ОХУ, Польшийн ЗГ-тай хэлэлцээ хийх шатандаа явж байна.</p> <p>Эдгээр арга хэмжээг хэрэгжүүлснээр хүнсний ногооны механикжуулалтын түвшин 42.0 хувьд хүрсэн.</p> <p style="text-align: right;">ХШҮ-100</p> <p><i>2.2. Хүнсний ногоог ялгаж дугаарлах, сортлох, савлах төхөөрөмж, гар багажны хангамжийг сайжруулах;</i></p> <p>Хүнсний ногоог ялгаж дугаарлах, сортлох, савлах төхөөрөмж, гар багажны хангамжийг сайжруулах чиглэлд тоног төхөөрөмж нийлүүлэгдээгүй.</p> <p style="text-align: right;">ХШҮ-0</p> <p><i>2.3. Өрхийн тариалан эрхлэгчид сайн дураараа хорших, хуулийн этгээд байгуулах, нэгдсэн байдлаар техник, тоног төхөөрөмжийг худалдан авахад нь санхүү, эрх зүйн зөвлөмж болон зээл, хөрөнгө оруулалт, санхүүгийн дэмжлэг үзүүлэх;</i></p> <p>“Хоршоолсон хэлбэрээр хүнсний ногоо эрхлэх замаар өрхийн амьжиргааг сайжруулах” төслийн хүрээнд 4 аймгийн 4 сум тус бүрт 10 өрхийг 1 бүлэг хоршооны зохион байгуулалтанд 200 ногоочинг хамруулан хэрэгцээт трактор, хүлэмж, зоорь, усалгааны тоног төхөөрөмжийг олгох менежмент хийгдэнэ. Монгол ногоо төслөөр 2018 онд Төв аймгийн Зуун мод суманд “Атрын шим” хүлэмжийн</p>

		<p>аж ахуйг түшиглэн “Хүлэмжийн экстейншин төв”-ийн 6х10м харьцаатай сургалтын танхим болон сургалтанд оролцогсод байрлах байрны барилгыг барьж ашиглалтад оруулсан. Уг төв нь танхимын сургалт явуулахаас гадна, хүлэмжийн аж ахуйд нэвтрээд байгаа Солонгос технологи, төрөл бүрийн таримал дээр биечлэн дадлага хийх боломж олгож байгаагаараа онцлог юм.</p> <p>Төвийн бүсийн загвар экстейншин төвүүдийн туршилтын талбайд шинэ төрөл зүйлийн болон сортын сорилт, УХ-н хүрээлэнтэй хамтарсан шинэ ургамал хамгааллын бодис турших судалгааны ажил, бага оврын техникийн түрээс, ногооны үр, УХБ-ын борлуулалт, сар тутам ногоочдын хүсэлтийн дагуу технологийн сургалтуудыг зохион байгуулан ажиллаж байна.</p> <p>Мөн баруун бүсэд 2018 онд Ховд аймгийн Ус ашиглагчдын холбоо, зүүн бүсэд Дорнод аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний Сургалтын төвтэй хамтран сургалтын байр, үзүүлэнгийн талбай, үрийн дэлгүүр бүхий материаллаг баазыг түшиглэн экстейншин төвийг ажиллуулж байна.</p> <p style="text-align: right;">ХШҮ-40</p> <p><i>2.4. Хүнсний ногооны үйлдвэрлэлд ажиллаж байгаа залуу гэр бүл, залуучуудад гарааны болон санхүүгийн дэмжлэг олгож, ажлын байртай болгох, тэдний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих;</i></p> <p>Хүнсний ногоо хөтөлбөрийн хүрээнд 625 залуу өрхөд шинээр ногоо тариалахад нь 10 нэр төрлийн үр олгож технологийг зааж зөвлөж сургалт явуулснаар 240 га талбайд тариалж, 1920 тн ургац хураан авч өрхийн хэрэгцээгээ хангахад нь дэмжлэг үзүүлэв. Хүлэмж, ил талбайн төрөл бүрийн ногоо ургуулах, үрслэг бэлтгэх, арчилгааны үеийн дадлагажих сургалтыг шинэ тариаланчдын хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн орчин үеийн арга техникийг танилцуулж, гардан гүйцэтгэхэд оролцуулах замаар дадлагажуулах сургалтыг Төв аймаг Зуунмод хот “Атрын шим” хүлэмжийн аж ахуйд 8 аймгийн 10 сумын тариаланчдыг дадлагажуулав.</p> <p style="text-align: right;">ХШҮ-70</p> <p><i>2.5. Хүнсний ногоо тариалахад тохирсон эрчим хүчний зарцуулалт багатай, ус хэмнэлттэй зарцуулдаг, байгаль орчинд халгүй, хямд төсөр усалгааны арга болох дуслын усалгаа, хөрсөн дотроос нэвчүүлэх усалгаа зэрэг дэвшилттэй технологи нэвтрүүлэх;</i></p> <p>БНХАУ-ын хөнгөлөлттэй зээлийн 97.8 мянган америк долларын хөрөнгөөр бага оврын 80 ширхэг бороожуулагч худалдан авснаар 80-100 га талбайн хүнсний ногооны усан хангамж сайжрах боломж бүрдэж байгаа бөгөөд ногоочдод хөнгөлөлттэй нөхцлөөр урт хугацааны зээлээр олгоно. Тоног төхөөрөмжийг хүлээн авсан ба 2019 онд ашиглахаар бэлтгэл ажил хийгдэж байна.</p> <p style="text-align: right;">ХШҮ-40</p> <p><i>2.6. Гэрийн болон үйлдвэрийн аргаар боловсруулсан хүнсний ногооны стандартыг боловсруулж мөрдүүлэх;</i></p> <p>Хүнсний ногооны стандартууд шинээр боловсруулах, шинэчлэх стандартуудад хийгдсэн шинжилгээний дүнд 2018 онд 52 стандарт хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаагийн 25 стандартад нэмэлт өөрчлөлт оруулах, 5 стандартыг хүчингүй болгох, 30 стандарт шинээр боловсруулах шаардлага байна гэсэн дүгнэлтийг ажлын хэсэг гаргасан. Үүний үр дүнд Стандарт, хэмжилт зүйн үндэсний зөвлөлийн 2018 оны 2-р сарын 22-ны өдөр гарсан тогтоолд дурдсаны дагуу Монгол ногоо төсөл хүнсний ногооны 9 стандартын төсөл шинээр боловсруулах, 19 стандарт шинэчлэх ажлыг зохион байгуулах, техникийн хороогоор хэлэлцүүлж, батлуулах, санхүүжүүлэхээр тусгагдсан. Энэ ажлын хүрээнд нийт 26 стандартыг төрлөөр нь багцлан нийт 11 зөвлөх 4 багаар 231 хүн-</p>
--	--	---

		<p>өдөр ажиллаж, Стандартчиллын үндэсний зөвлөлийн Хүнсний стандартчиллын техникийн хороогоор 2019 онд хэлэлцүүлэн батлуулахад бэлэн болоод байна.</p> <p style="text-align: right;">ХШҮ-70</p> <p>2.7. <i>Услалтын системийн барилга байгууламж, тоног төхөөрөмжийг шинэчлэх, дэд бүтцийг сайжруулах замаар ногоочдын бүлэг, хоршоодыг дэмжин нэгж талбайгаас авах бүтээгдэхүүний хэмжээг нэмэгдүүлэх;</i></p> <p>АХБ-ны санхүүжилтээр “Хоршоолсон хэлбэрээр хүнсний ногоо эрхлэх замаар өрхийн аж ахуйг сайжруулах” төслийн хүрээнд Увс аймгийн Улаангом сумын 500 га, Төв аймгийн Борнуур сумын 920 га талбайн толгойн барилга байгууламжийг сэргээн засварлах төсөл эхэлсэн. Энэ ажлын хүрээнд 4000 өрхийн ногооны талбайг услах боломж бүрдэнэ.</p> <p style="text-align: right;">ХШҮ-40</p> <p>2.8. <i>Инженерийн хийцтэй томоохон услалтын систем бүхий иргэн, аж ахуйн нэгж таримлын сэлгээндээ хүнсний ногоо тариалах санаачилгыг дэмжих замаар үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдүүлэх;</i></p> <p>Хөвсгөл аймгийн Тосонцэнгэл сумын “Ногооны талбайн усжуулалтын системийн өргөтгөл их засварын ажлыг улсын төсвийн 185.8 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар хийснээр 95.0 га хүнсний ногооны талбайг усалгаажуулах боломж бүрдсэн. Сармисны үр үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор Монгол ногоо төслийн хүрээнд Завхан аймгийн Лааны булан дахь 18 га талбайг усжуулахад зориулан 240 м суваг татах, цементэн хаалт барихад санхүүгийн дэмжлэг үзүүлсэн Уг суваг, шуудуйгаар нийт Лааны буланд ногоо тарьдаг 60 өрхийн усалгааны асуудлыг шийдвэрлэсэн. Эдгээр ажлыг хэрэгжүүлснээр хүнсний ногооны усалгаатай нэг га-н ургац 15 цн нэмэгдээд байна.</p> <p style="text-align: right;">ХШҮ-70</p> <p>2.9. <i>Байгальд ээлтэй, эрчим хүчний хэмнэлттэй хөргөлт, халаалтын технологитой стандарт бүхий зоорийн аж ахуйг нэмэгдүүлэх;</i></p> <p>Сэлэнгэ аймгийн Жавхлант, Баян-Өлгий аймгийн Баяннуур сумдад тус бүр улсын төсвийн 100.0 сая, Ховд аймгийн Жаргалант суманд 400.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар хүнсний ногооны зоорь байгуулах тендерээр 1300 тн багтаамжтай зоорь ашиглалтад оруулснаар зоорийн нийт багтаамж 202.3 мянган тоннд хүрсэн.</p> <p style="text-align: right;">ХШҮ-70</p> <p>2.10. <i>Таримлын төрөлд зохицсон зориулалтын зоорь, агуулах байгуулах иргэн аж ахуйн нэгжид дэмжлэг үзүүлж, импортыг бууруулах;</i></p> <p>Монгол ногоо төслийн хүрээнд Хэнтий аймгийн Мөрөн суманд сармис хадгалах, Сэлэнгэ аймгийн Мандал суманд байцаа хадгалах, Сэлэнгэ аймгийн Зүүнбүрэн суманд сонгино хадгалах зориулалтын 300 тн-ын зоорийг ашиглалтад оруулсан. Зоорийн санхүүжилт нь төслөөс 70 хувь, өрхийн 30 хувийн оролцоотой шийдвэрлэсэн. 2018 оны импортын мэдээгээр байцаа бусад навчит ногоо, лууван, манжин бусад үндэс үрт болон амтат гуа, тарвас, өргөст хэмхийн хэмжээ буурсан үзүүлэлттэй гарсан нь дотоодын үйлдвэрлэл нэмэгдсэнтэй холбоотой.</p> <p style="text-align: right;">ХШҮ-70</p> <p>2.11. <i>Хүнсний ногоо тариалагчид үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ чанар, стандартад нийцүүлэн зах зээлд нийлүүлэх, борлуулалтын дотоод сүлжээ бий болгох боломжийг бүрдүүлэх;</i></p>
--	--	---

		<p>“Монгол ногоо” төслөөр хүнсний ногоо хатааж хадгалах бага оврын хатаах төхөөрөмжийг нийлүүлж Төв, Сэлэнгэ, Дархан-Уул аймгийн найман суманд технологийн сургалт зохион байгуулсан. Secim төсөлтэй хамтран хүнсний ногоо болон сав баглаа боодол, хаяг, шошго, хадгалалт, тээвэрлэлт, агуулах зэрэг стандартыг үнэлж, шинэчлэн сайжруулах, санал боловсруулах чиглэлээр ажлын хэсэг байгуулж, 2 удаа хэлэлцүүлэг зохион байгуулж, шаардлагатай стандартыг шинэчлэн боловсруулахаар болов. Төмс, хүнсний ногооны хадгалалтын үеийн хэвийн хорогдлыг тооцох аргачлалын төслийг Монголын хөдөөг шинэчлэх фермерүүдийн холбоо, Ногоочдын холбоо зэрэг ТББ-аар хэлэлцүүлж, ХХААХҮ-ийн Сайдын А-43 тушаалаар батлуулсан. Аймаг, орон нутагт хүргүүлж, сурталчилж хэрэгжүүлж ажиллана.</p> <p style="text-align: right;">ХШҮ-40</p> <p>2.12. Хүнсний ногоо тариалагчид үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ чанар, стандартад нийцүүлэн зах зээлд нийлүүлэх, борлуулалтын дотоод сүлжээ бий болгох боломжийг бүрдүүлэх;</p> <p>Польш улсын 12.7 сая еврогийн хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрээр Хүнсний ногооны үйлдвэрлэлд нэмүү өртгийн сүлжээ бүрдүүлэх төслийн санал боловсруулж СЯ-нд хүргүүлсэн.</p> <p>Энэхүү төслийн талаархи танилцуулга, явцыг УИХ-ын эдийн засгийн болон Төсвийн байнгын хороогоор хэлэлцүүлэн дэмжигдсэн. УИХ-аар соёрхон баталсанаар 7 сараас зээлийн төсөл хэрэгжих боломж бүрдэж, аймгуудад 3.0 мянган тн багтаамжтай зоорь баригдана.</p> <p style="text-align: right;">ХШҮ-40</p> <p>2.13. Хүнсний ногооны борлуулалтыг төрийн худалдан авалт (боловсрол, эрүүл мэнд, батлан хамгаалах, хууль сахиулах болон уул уурхай)-аар дэмжих бодлого, зохицуулалтын арга хэмжээ авах.</p> <p>Дархан-уул, Сэлэнгэ, Төв аймгийн нийт 4 сумын 4 хоршоонд төмс, хүнсний ногоог хадгалах, дамжуулан борлуулах төв байгуулахад Монгол ногоо төслөөс 88.0 сая төгрөгийн дэмжлэг, орон нутгийн тариаланчдаас 39.0 сая төгрөг нийт 127.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 500.0 тонн багтаамжтай зоорийг шинээр ашиглалтад орууллаа. Үүний үр дүнд хоршоодын төмс, хүнсний ногооны үйлдвэрлэл, хадгалалтын менежмент сайжирсан. Хоршоод үйл ажиллагаагаа тогтворжуулснаар бүтээгдэхүүнээ 30-40% өндөр үнээр борлуулж, өрсөлдөх чадвар нэмэгдэж байна. Түүнчлэн жилийн турш хүнсний ногооны хангамж тогтворжих байдал нэмэгдсэн. Төрийн худалдан авалтал дотоодод ургуулсан төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнийг гарал үсэл чанар стандартын шаардлагад нийцүүлэн худалдан авах төсөлд санал өгсөн.</p> <p style="text-align: right;">ХШҮ-40</p> <p style="text-align: center;">Зорилт 2-ын биелэлтэд хийсэн ХШҮ-ний дундаж дүн 45.4 хувь</p>
	<p>“Хүнсний ногооны үр үйлдвэрлэлийг дэмжиж, ирээдүйтэй болон нутагшсан сортыг туршиж, үйлдвэрлэлд нэвтрүүлэн үрийн чанарыг сайжруулж, хангамжийг нэмэгдүүлэх” 3-р зорилтын хүрээнд:</p>	<p>3.4. Хүнсний ногооны үрийн тариалан эрхлэгчдэд сэлгээний талбай нэмж олгох ажлыг зохион байгуулах;</p> <p>Хүнсний ногооны үрийн тариаланг хөгжүүлэх боломж бүхий Увс, Баянхонгор, Хэнтий, Завхан, Сэлэнгэ, Дархан-уул, Өмнөговь аймгийн удирдлагуудад албан хүсэлт илгэж хамран ажилласнаар үрийн тариалангийн талбай 100 га талбайгаар нэмэгдсэн. Цаашид талбайг усалгаажуулах, тог татах, хүлэмж, эх ургамлын зоорь барих ажлууд АХБ-аас хэрэгжих төсөл болон БНСУ-ын Копиа төслийн хүрээнд хийгдэх эхний алхамууд хийгдсэн болно.</p> <p style="text-align: right;">ХШҮ-100</p> <p>3.5. Ногооны шинэ сорт бүтээх, шинэ таримал туршиж, тэдгээрийн элит сортын баталгаат үр үржүүлгийг дэмжиж,</p>

		<p><i>шинжлэх ухаан, технологийн төслийг захиалан эрдэм шинжилгээний байгууллагуудаар гүйцэтгүүлэх.</i></p> <p>Хүнсний ногооны 16 зүйлийн 94 сортын үрийг үр үйлдвэрлэдэг Голланд улсын “Бейо”, Герман улсын “Сатимекс” зэрэг компаниудаас оруулж ирэн сорилтонд оруулав. Эдгээр сортуудыг Монгол ногоо төслийн хүрээнд төвийн бүсэд байгуулагдсан загвар экстейншиний 3 төвүүдийг түшиглэн, УГТХ-ийн Ногооны секторын судлаачдын удирдлага доор хийж гүйцэтгэв. Үүний үр дүнд ногоочид сорт сорилтын шатанд явж байгаа сортуудтай ургалтын хугацаанд нь өсөлт, хөгжилт, технологитой танилцах боломжийг бүрдүүлсэн. Мөн экстейншин төвүүд бие даан шинэ таримал үр сортуудыг турших, судлах дадлага, туршлагатай болох нөхцлийг бүрдүүллээ. 2018 онд Улсын сорт сорилтын зөвлөл хуралдаанд ирээдүйтэй сортоор шинэ таримал болох порей сонгины 1 сортыг, нутагшснаар бөөрөнхий байцааны 1 сортыг батлууллаа. Ийнхүү голлох нэр төрлийн хүнсний ногооны хувьд 10 нутагшсан, 17 ирээдүйтэй сорт, 13 эрлийз ирээдүйтэй сорт шинээр батлагдлаа.</p> <p style="text-align: right;">ХШҮ-70</p> <p>Зорилт 3-ын биелэлтэд хийсэн ХШҮ-ний дундаж дүн 85.0 хувь</p>
<p>“Хүнсний ногооны үйлдвэрлэл эрхлэгчдийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, мэргэжилтэй ажилтан бэлтгэх, давтан сургах, мэдээллээр хангах замаар хүний нөөцийн чадавхийг сайжруулах” 4-р зорилтын хүрээнд:</p>		<p><i>4.1. мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвд ногоочин, техникийн ажилтан бэлтгэх төрөлжсөн анги, сургалтын тоог нэмэгдүүлэх, суралцах сонирхолтой, сургуулиа төгсөөд ажиллах боломжтой залуучуудыг хөнгөлөлттэй нөхцөлөөр сургах, мэргэшүүлэх;</i></p> <p>Дархан-Уул аймагт ХААИС-тай хамтарч 3 дугаар сарын 27-31-ний өдрүүдэд аймгуудын газар тариалангийн асуудал хариуцсан мэргэжилтнүүдэд зориулсан сургалт, талбайн өдөрлөг зохион байгуулав. Тус талбайн өдөрлөгт нийт 40 агрономи, инженер техникийн ажилтан оролцож хүлэмжийн аж ахуй, хүнсний ногооны үйлдвэрлэлд шинээр нэвтэрч буй техник, технологийг судалсан. Архангай аймгийн ХХААГ-тай хамтран ХАА-н үйлдвэрлэлд шинээр нэвтэрч буй дэвшилтэт техник ашиглалтын талбайн өдөрлөг зохион байгуулсан. Тус өдөрлөгт газар тариалангийн салбарт үйл ажиллагаа явуулж буй 60 гаруй тариаланч оролцсон.</p> <p style="text-align: right;">ХШҮ-40</p> <p><i>4.2. салбарын эрдэмтэн, мэргэжилтнүүдийг гадаад орнуудын үр үйлдвэрлэх, хүлэмжийн аж ахуй, усалгааны шинэ техник, зоорийн тоног төхөөрөмжтэй танилцуулах, олон улсын үзэсгэлэнд оролцуулах, сургаж дадлагажуулах замаар хүнсний ногооны тариалалт, үйлдвэрлэлийн шинэ технологи эзэмшүүлэх;</i></p> <p>Монгол ногоо төслийн хүрээнд экстейншин төвийн агрономчдыг Япон улсын Хоккайдо мужийн “ХАА-н нэвтрүүлэх төв” дээр чиглүүлэх сургалтанд хамруулав. “Ногоон долоо хоногийн хүрээнд зохион байгуулагдсан үзэсгэлэнд тавигдах хүнсний ногооны шинэ сорт, тоног төхөөрөмжтэй танилцах, үрийн Сатимекс компанитай Дистрибьюторын гэрээ байгуулав. БНХАУ-ын хүлэмжийн аж ахуйн шинэ, болон уламжлалт техник технологитой танилцах, тариаланчдын борлуулалтын сүлжээ, зохицуулалт зэрэгтэй танилцав. Талбайн өдөрлөгт оролцож, сорт, үр үйлдвэрлэл, Голландын хүнсний ногооны үйлдвэрлэлийн техник, технологитой танилцаж, өөрийн оронд нэвтрүүлж, ашиглаж болохуйц тоног төхөөрөмжийг судлав. БНСУ-д “Зохистой дадал, гэрчилгээжүүлэх, органик бүтээгдэхүүн” сэдэвт сургалтад хамрагдав. Үүний үр дүнд зохистой дадлын хялбаршуулсан журам боловсруулах ажлын хэсэгт ажиллаж төслийн эхний хувилбарыг боловсруулав.</p> <p style="text-align: right;">ХШҮ-100</p> <p><i>4.3. хүн амд дотоодын хүнсний ногоог зохистой хэрэглэхийн ач тусыг ойлгуулах, сурталчлах ажлыг зохион байгуулах;</i></p>

	<p>Төвийн болон зүүн бүсэд ургамал хамгааллын бэлдмэл найруулах технологи, цацахад анхаарах зүйл, хөдөлмөр хамгаалал, УХБ-ын хадгалалтын нөхцөл, аюулгүй байдал, сав баглааны устгал хийх, гербицид, инсектицид, фунгицид хэрэглэх технологи, био-пестицидийн хэрэглээ, талбайг өвчин, хортон, хог ургамлаар бохирдохоос урьдчилан сэргийлэх бусад аргууд зэрэгт суралцан, сургалтын өмнө болон хойно тест авч, сургалтын гэрчилгээ олгов. Сургалтад 300 ногоочин хамрагдав.</p> <p style="text-align: right;">ХШҮ-40</p> <p><i>4.4. хүнсний ногоо тариалах, арчлах, ургацыг хадгалах, боловсруулах технологи, арга ажиллагааг хэвлэл мэдээллийн хэрэгслээр нэвтрүүлж, сурталчлах ажиллагааг өргөжүүлэх;</i></p> <p>ШХА-аас хэрэгжүүлж байгаа Монгол ногоо төсөл, УХЭШХ-тэй хамтран хөнөөлт организмын тархалтын судалгааны үр дүнг үндэслэн аймаг, сумдын агрономчид, хөдөө аж ахуйн мэргэжилтнүүдэд зориулан тариалангийн талбайд тархсан хог ургамал, хортон шавьж, ургамлын өвчний эсрэг авч хэрэгжүүлэх ургамал хамгааллын зохистой арга хэмжээний талаар болон боловсруулсан заавар, зөвлөмжийг танилцуулах зорилгоор 4-5 дугаар сард 2 удаагийн сургалт зохион байгуулж 200 ногоочинг хамруулав. Мөн улсын үзүүлэх сургалтаар 21 аймгийн агрономчид, ногоочид оролцсон 300 гаруй хүнд мэдээлэл түгээв.</p> <p>Хүнсний ногооны аюулгүй байдал, эрүүл ахуй, гарал үүслийн талаар Монголын үндэсний олон нийтийн радио телевиз, Тв-5 телевизүүдэд цаг үеийн асуудлаар мэдээлэл хийж, хүнсний ногоо тариалах, арчлах, ургацыг хадгалах, боловсруулах технологи, арга ажиллагааг сурталчилсан.</p> <p>“Монгол ногоо” төслийн хүрээнд Сонгино хайрхан, Налайх дүүргүүдэд хэрэгжиж буй “Тудамж” төсөлд хамрагдсан өрхийн тариалангийн үйлдвэрлэлийн ач холбогдол, борлуулалт, эдийн засгийн үр өгөөж, таримлын технологийн талаар баримтат кино хийж, олон нийтийг хамарсан зөвлөгөөн, семинар, үзэсгэлэн худалдааны үеэр хэрэглэгчид болон ногоочдод танин мэдэхүйн мэдээлэл, зөвлөл хүргэж ажилласан.</p> <p style="text-align: right;">ХШҮ-100</p> <p><i>4.5. хамгаалагдсан хөрсний аж ахуй эрхлэгчдийг харилцан туршилага судлуулах, гидропоник орчинд ургуулах арга, технологи нэвтрүүлэх, аймаг, орон нутагт үзүүлэх сургалт зохион байгуулах;</i></p> <p>Хүлэмжийн тариалалтын үед гарах хөнөөлт организмтой тэмцэх тухай үзүүлэх сургалтыг 10 дугаар сард Төв аймгийн “Атарын шим” ХХК-ий хүлэмжид зохион байгуулсан. Сургалтын үеэр химийн бодисын хэрэглээг багасгах зорилгоор хүлэмжийг хортон шавьжны эсрэг наалдуулагч цаас ашиглах, таримлын өвчний эсрэг биологийн бэлдмэл ашиглах зэрэг аюулгүй аргыг хэрхэн хэрэглэх тухай үзүүлэх сургалт зохион байгуулсан. Үр үржүүлэгчдэд эх ургамлыг бэлтгэх, хүнсний ногооны үрийн тариалангийн технологи, өвчин, хортонтой тэмцэх талаар сургалт хийсэн. Сургалтад 12 аймгийн 24 сум, нийслэлийн 6 дүүргийн нийт 120 ногоочинг хамруулав.</p> <p style="text-align: right;">ХШҮ-100</p> <p><i>4.6. усалтын систем, усалгааны тоног төхөөрөмжийн ашиглалт, таримлын ус хэрэглээ, технологийн талаар хүнсний ногоо тариалагчдад зориулсан сургалт зохион байгуулах, сурталчилгаа хийх;</i></p> <p>БНХАУ-ын Засгийн газрын 16.9 сая америк долларын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр 50-125 га талбайг услах үр тарианы зориулалттай усалгааны тоног төхөөрөмж 130 ширхэг, төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнийг услах зориулалттай бага болон</p>
--	---

	<p>дунд оврын усалгааны тоног төхөөрөмж 126 ширхэг, 0.8-1.0 тpa даралттай усалгааны хуванцар хоолой нийлүүлэх гэрээг “Foton Iovol” ХХК-тай байгуулж, урьдчилгаа санхүүжилтийг СЯ-аар дамжуулан БНХАУ-ын Экзим банкинд хүргүүлж 24.1 тэрбум төгрөгийн санхүүжилт хийсэн. Услалтын системийн тоног төхөөрөмж угсрах, технологи дамжуулах, усны ашиглалт хэрэглээний талаар сургалтыг 2019 онд зохион байгуулна.</p> <p style="text-align: right;">ХШҮ-0</p> <p><i>4.8. ногоочдыг сайн дураараа зохион байгуулалтад оруулж, ургацаа төв суурин газарт борлуулах ажлыг мэргэжлийн холбоодын оролцоотой зохион байгуулж, арга зүйн сургалт, сурталчилгаа хийх;</i></p> <p>Улаанбаатар хотод төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнийн хадгалалт борлуулалтын цогцолбор төв байгуулах ТЭЗҮ боловсруулах зөвлөх үйлчилгээний тендерт “ХБХДТ” ХХК шалгарч, ТЭЗҮ, эскиз зураг боловсруулах ажлыг дууссан. Барилгын тухай хуульд заасны дагуу мэргэжлийн байгууллагаар Ажлын зургийг баталгаажуулахаар хянуулж байна. Нийслэлээс тус төвийг байгуулах 9.6 га талбайг СХД-ийн 20 дугаар хороо, Сонсголонд олгохоор шийдвэрлэсэн.</p> <p style="text-align: right;">ХШҮ-40</p> <p><i>4.10. хүнсний ногооны түгээмэл өвчин, хортон шавж, хог ургамлыг таних зорилго бүхий каталогийг хэвлүүлэн түгээх, хөнөөлт организмтай хүн, мал, амьтан, байгаль орчинд ээлтэй аргаар тэмцэх технологийн сургалт, семинарыг зохион байгуулах;</i></p> <p>Ил талбайн болон хүлэмжийн хүнсний ногооны өвчин хортон, шавж, хог ургамлыг таних талбайн сургалтыг зүүн бүсэд Дорнод аймагт, баруун бүсэд Ховд аймагт, төвийн бүсэд Дархан-уул, Орхон аймагт зохион байгуулж нийт 500 гаруй ногоочин, мэргэжилтэнг хамруулав. Гарын авлага, зөвлөмжөөр хангав.</p> <p style="text-align: right;">ХШҮ-100</p> <p><i>4.11. Борлуулалтыг дэмжих, бүтээгдэхүүнийг сурталчлах зорилгоор “Алтан намар” үзэсгэлэн-худалдааг бүх сум, дүүрэг, хороодод зохион байгуулж, орон нутагт туршилага солилцох, үзүүлэх сургалт хийх.</i></p> <p>“Алтан намар-2018” үзэсгэлэн худалдаанд нийслэлийн 6 дүүрэг, 12 аймгийн 21 сумын нийт 240 гаруй ногоочин, 8 аж ахуйн нэгж, 11 хоршоо, “Монгол ногоо”, “Глобал коммунитис” олон улсын байгууллага, “Адра” төсөл, ХААИС-ийн Агробиологийн их сургууль, ХААШУОҮНТ, “Монголын хөдөөг шинэчлэхийн төлөө фермерүүдийн холбоо”, “Хөдөө аж ахуйн бүтээмжийн төв”, “Хүлэмжийн холбоо”, “Ногоочдын холбоо” зэрэг ТББ-ууд 40 гаруй нэр төрлийн 860 тн хүнсний ногоо, төмс, 8 нэрийн таримал болон байгалийн жимс, жимсгэнэ, 6 нэрийн гоёл чимэглэлийн мод бутны суулгац, ногооны үр, 60 гаруй нэрийн эмийн ургамал, 14 нэрийн тасалгааны цэцэг зэрэг бүтээгдэхүүнээр оролцож, нийт 981.0 сая төгрөгийн борлуулалт хийсэн байна. Үзэсгэлэн худалдааны үеэр ХААИС-ийн Агробиологийн их сургуулийн экспресс лаборатори 300 гаруй ургамлын гаралтай дээж бүтээгдэхүүнд шинжилгээ хийж, захиалагч ХХААХҮЯ, ногоочид болон хэрэглэгчдэд шинжилгээний хариуг танилцуулан эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдлын зөвлөгөө өгсөн. Аймаг, сум бүр ногооны үзэсгэгсгэлэн худалдаа, борлуулалтыг дэмжиж өдөрлөг зохион байгуулж хэвшсэн. “Хүнсний ногоо-2018” Улсын үзүүлэх сургалтыг 08 сарын 05-10-ны өдөр хөтөлбөр, маршрутын дагуу Дорнод аймагт зохион байгуулж, 200 ногоочин, агрономи, төрийн болон ТББ, эрдэм шинжилгээний хүрээлэнгийн эрдэмтэд оролцов.</p>
--	---

		ХШҮ-100 Зорилт 4-ийн биелэлтэд хийсэн ХШҮ-ний дундаж дүн 68.8 хувь
7.	Дүгнэлт (ололт, дутагдал, анхаарах асуудлууд)	<p>Өрхийн тариалан эрхлэгч болон хүнсний ногооны төрөлжсөн аж ахуйн нэгж, хоршоог дэмжих замаар хүнсний ногооны үйлдвэрлэлийг хөгжүүлж, дотоодын хэрэгцээгээ жилийн турш тогтвортой хангах зорилготой “Хүнсний ногоо” үндэсний хөтөлбөрийг Засгийн газрын 2017 оны 278 дугаар тогтоолоор батлуулан хэрэгжүүлэх ажлыг улсын хэмжээнд зохион байгуулж, аймгуудад “Хүнсний ногоо” дэд хөтөлбөр батлан хэрэгжүүлж байна.</p> <p>Хөтөлбөрийн хүрээнд 2018-2022 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж ХХААХҮ-ийн Сайдын 2018 оны 07 дугаар 25-ны өдрийн А-127 дугаар тушаалаар батлуулж, хэрэгжүүлэх ажлыг улсын хэмжээнд зохион байгуулж байна.</p> <p>Хөтөлбөр хэрэгжсэнээр хүнсний ногоо тариалдаг 951 аж ахуйн нэгж, 16249 иргэн 8676.7 га-д хүнсний ногоо тариалсан. Эдгээр хүнсний ногоо тариалсан аж ахуйн нэгжийн 36.2 хувь, иргэдийн 48.2 хувь нь шууд хөтөлбөрийн үр шимийг хүртсэнээр 2018 онд нийт 102253.0 тонн хүнсний ногоо хурааж авсан байна. Ингэснээр 2017 оноос тариалсан талбай 896.7 га буюу 10.34 хувиар, хураан авсан ургац 22006 тонн буюу 21.5 хувиар нэмэгдсэн бодитой үр дүн гарсан байна.</p> <p>“Хүнсний ногоо”, “Жимс, жимсгэнэ” хөтөлбөрүүдийн улсын үзүүлэх сургуулийг 2018 оны 08 дугаар сарын 05-ны өдрөөс, 09-ний өдрүүдэд Дорнод аймагт аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газартай хамтран зохион байгуулж, 21 аймгийн холбогдох мэргэжилтэн, ногоочин, жимсчин нийт 201 төлөөлөл оролцон хүнсний ногоо, жимс жимсгэнэ тариалах мэдлэг, туршлагаа солилцов.</p> <p>Гол үр дүнгүүд:</p> <ul style="list-style-type: none"> ✓ 20 га талбайд “Өвлийн хүлэмжийн аж ахуй байгуулах” төсөл, жил бүрийн 11 дүгээр сарын 01-нээс 05 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл хугацаанд оройн 22 цагаас өглөөний 06 цагийн хооронд өвлийн хүлэмжийн ахуйд хэрэглэсэн цахилгааны төлбөрөөс 1 м² талбайд 0.762 кв/цаг-аар тооцож 100 хувь чөлөөлөх тухай Засгийн газрын 2018 оны 324 дүгээр тогтоолыг батлуулсан. ✓ Улсын төсвийн хөрөнгөөр 32 м² талбай бүхий 160 ширхэг нийлэг хальсан хүлэмж нийлүүлэх тендер шалгаруулж, ХХААХҮЯ-ны төрийн нарийн бичгийн даргын А/600 дугаар тушаалаар гэрээ байгуулан зуны хүлэмжийн үйлдвэрлэлийг 5120 м² талбайгаар нэмэгдүүлсэн. ✓ 2018 онд Жижиг, дунд үйлдвэрлэл хөгжүүлэх сангаас 3 га талбайд өвлийн хүлэмж байгуулах 12 иргэн, аж ахуйн нэгжид 4.2 тэрбум төгрөгийн зээлийн дэмжлэгт хамрагдсан. Ингэснээр 2018 онд хүлэмжийн талбай 91.6 га болж 5750 тонн ургац хураан авсан байна. Энэ нь 2016 оноос хүлэмжийн талбай 15.6 га талбай, ургац 610 тн-оор нэмэгдэв. ✓ Хүнсний ногооны техникийн шинэчлэлийн хүрээнд улсын төсвийн 1.7 тэрбум төгрөгийн хөрөнгөөр дунд оврын 19 трактор, хүнсний ногооны 27 иж бүрдэл техник худалдан авснаар 600 га талбайн хүнсний ногооны хөрс боловсруулах, арчлах, хураах ажлыг механикжуулах боломж бүрдүүлэв.

	<p>✓ Хүнсний ногооны стандартууд шинээр боловсруулах, шинэчлэх стандартуудад хийгдсэн шинжилгээний дүнд 2018 онд 52 стандарт хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаагийн 25 стандартад нэмэлт өөрчлөлт оруулах, 5 стандартыг хүчингүй болгох, 30 стандарт шинээр боловсруулах шаардлага байна гэсэн дүгнэлтийг ажлын хэсэг гаргасан. Үүний үр дүнд Стандарт, хэмжилт зүйн үндэсний зөвлөлийн 2018 оны 2-р сарын 22-ны өдөр гарсан тогтоолд дурдсаны дагуу Монгол ногоо төсөл хүнсний ногооны 9 стандартын төсөл шинээр боловсруулах, 19 стандарт шинэчлэх ажлыг зохион байгуулах, техникийн хороогоор хэлэлцүүлж, батлуулах, санхүүжүүлэхээр тусгагдсан. Энэ ажлын хүрээнд нийт 26 стандартыг төрлөөр нь багцлан нийт 11 зөвлөх 4 багаар 231 хүн-өдөр ажиллаж, Стандартчиллын үндэсний зөвлөлийн Хүнсний стандартчиллын техникийн хороогоор 2019 онд хэлэлцүүлэн батлуулахад бэлэн болоод байна.</p> <p>✓ Сэлэнгэ аймгийн Жавхланта, Баян-Өлгий аймгийн Баяннуур сумдад тус бүр улсын төсвийн 100.0 сая, Ховд аймгийн Жаргалант суманд 400.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар хүнсний ногооны зоорь байгуулах тендерээр 1300 тн багтаамжтай зоорь ашиглалтад оруулснаар зоорийн нийт багтаамж 202.3 мянган тоннд хүрсэн.</p> <p>✓ Хүнсний ногооны 16 зүйлийн 94 сортын үрийг үр үйлдвэрлэдэг Голланд улсын “Бейо”, Герман улсын “Сатимекс” зэрэг компаниудаас оруулж ирэн сорилтонд оруулав. Эдгээр сортуудыг Монгол ногоо төслийн хүрээнд төвийн бүсэд байгуулагдсан загвар экстейншиний 3 төвүүдийг түшиглэн, УГТХ-ийн Ногооны секторын судлаачдын удирдлага доор хийж гүйцэтгэв. Үүний үр дүнд ногоочид сорт сорилтын шатанд явж байгаа сортуудтай ургалтын хугацаанд нь өсөлт, хөгжилт, технологитой танилцах боломжийг бүрдүүлсэн. Мөн экстейншин төвүүд бие даан шинэ таримал үр сортуудыг турших, судлах дадлага, туршлагатай болох нөхцлийг бүрдүүллээ. 2018 онд Улсын сорт сорилтын зөвлөл хуралдаанд ирээдүйтэй сортоор шинэ таримал болох порей сонгины 1 сортыг, нутагшснаар бөөрөнхий байцааны 1 сортыг батлууллаа. Ийнхүү голлох нэр төрлийн хүнсний ногооны хувьд 10 нутагшсан, 17 ирээдүйтэй сорт, 13 эрлийз ирээдүйтэй сорт шинээр батлагдлаа.</p> <p>Хөтөлбөр батлагдсанаас ХХААХҮ-ийн сайдын багц, Жимс, жимсгэнэ дэд хөтөлбөрийн хүрээнд орон нутгийн хөрөнгө оруулалт, гадаадын төслөөс 2018 онд нийт 4.97 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн байна.</p> <p><i>“Хүнсний ногоо” үндэсний хөтөлбөрийн зорилт, арга хэмжээний ерөнхий гүйцэтгэл эхний жилийн байдлаар 67.0 хувьтай буюу үнэлэгдлээ. Цаашид хөтөлбөрийн санхүүжилтийг нэмэгдүүлж хэд хэдэн зорилтын хүрээнд заасан ажлыг эрчимжүүлэх шаардлагатай байна.</i></p> <p>Эдгээр арга хэмжээний удааширсан, хэрэгжээгүй шалтгаан нөхцлийг судалбал санхүүжилт, бэлтгэл ажил судалгааны түвшинд үр дүн хараахан гараагүй байгаа, хамтран хэрэгжүүлэгч зэргээс хамаарч байна.</p> <p>ЗӨВЛӨМЖ:</p>
--	--

		<p>1. “Дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх замаар хүнсний ногооны үйлдвэрлэлийг эрчимжүүлж, усалгаатай тариалангийн хэмжээ, агуулах, зоорийн багтаамжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн хувийн хөрөнгө оруулалтыг урамшуулах, шууд худалдааны сүлжээ, төрөлжсөн захыг дэмжин хөгжүүлэх” 2 дугаар зорилтын хэрэгжилт хамгийн хангалтгүй байгаад дүн шинжилгээ хийж ажиллах,</p> <p>2. “Хүнсний ногоо” үндэсний хөтөлбөрийн зорилт, арга хэмжээнээс хэрэгжилт хангалтгүй буюу 40 хувиар үнэлэгдсэн дараах арга хэмжээг эрчимжүүлэх, Үүнд:</p> <p>2.1. 1.1. <i>Өвлийн хүлэмжийн аж ахуйг байгуулахад хөнгөлөлттэй нөхцөлөөр зээлийн дэмжлэг үзүүлж, хот суурингийн хүн амыг жилийн турш шинэ ургацын ногоогоор хангах;</i></p> <p>2.2. 1.3. <i>Хүлэмжинд мөөг, ашигт таримал, гүзээлзгэнэ тариалахыг дэмжиж, гидропоник болон босоо тавиурт усан орчинд ногоо ургуулах дэвшилтэт технологийг нэвтрүүлж, нэгжийн ургацыг нэмэгдүүлэх;</i></p> <p>2.3. <i>Ургамал хамгааллын цогц арга хэмжээг хэрэгжүүлэх, зохистой дадал, шинэ технологийг нэвтрүүлэх замаар химийн бодисын хэрэглээг бууруулах</i></p> <p>2.4. 1.6. <i>Хүнсний ногооны тариалалт, хураалт, хадгалалтын технологийг хөрс, бордоо, ургамал хамгаалал, сорт, усжуулалт, механикжуулалт, хадгалалт, тээвэрлэлт, бүтээгдэхүүн үйлдвэрлэлтэй хамтад нь авч үзэн цогцоор нь боловсруулж тариалан эрхлэгч иргэн, аж ахуйн нэгжид зөвлөмж болгон хэрэгжүүлэх;</i></p> <p>2.5. 2.3. <i>Өрхийн тариалан эрхлэгчид сайн дураараа хорших, хуулийн этгээд байгуулах, нэгдсэн байдлаар техник, тоног төхөөрөмжийг худалдан авахад нь санхүү, эрх зүйн зөвлөмж болон зээл, хөрөнгө оруулалт, санхүүгийн дэмжлэг үзүүлэх;</i></p> <p>2.6. 2.5. <i>Хүнсний ногоо тариалахад тохирсон эрчим хүчний зарцуулалт багатай, ус хэмнэлттэй зарцуулдаг, байгаль орчинд халгүй, хямд төсөр усалгааны арга болох дуслын усалгаа, хөрсөн дотроос нэвчүүлэх усалгаа зэрэг дэвшилтэт технологи нэвтрүүлэх;</i></p> <p>2.7. 2.7. <i>Услалтын системийн барилга байгууламж, тоног төхөөрөмжийг шинэчлэх, дэд бүтцийг сайжруулах замаар ногоочдын бүлэг, хоршоодыг дэмжин нэгж талбайгаас авах бүтээгдэхүүний хэмжээг нэмэгдүүлэх;</i></p> <p>2.8. 2.11. <i>Хүнсний ногоо тариалагчид үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ чанар, стандартад нийцүүлэн зах зээлд нийлүүлэх, борлуулалтын дотоод сүлжээ бий болгох боломжийг бүрдүүлэх;</i></p> <p>2.9. 2.12. <i>Хүнсний ногоо тариалагчид үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ чанар, стандартад нийцүүлэн зах зээлд нийлүүлэх, борлуулалтын дотоод сүлжээ бий болгох боломжийг бүрдүүлэх;</i></p> <p>2.10. 2.13. <i>Хүнсний ногооны борлуулалтыг төрийн худалдан авалт (боловсрол, эрүүл мэнд, батлан хамгаалах, хууль сахиулах болон уул уурхай)-аар дэмжих бодлого, зохицуулалтын арга хэмжээ авах.</i></p> <p>2.11. 4.1. <i>мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвд ногоочин, техникийн ажилтан бэлтгэх төрөлжссөн анги, сургалтын тоог нэмэгдүүлэх, суралцах сонирхолтой, сургуулиа төгсөөд ажиллах боломжтой залуучуудыг хөнгөлөлттэй нөхцөлөөр сургах, мэргэшүүлэх;</i></p>
--	--	--

		<p>2.12. 4.3. хүн амд дотоодын хүнсний ногоог зохистой хэрэглэхийн ач тусыг ойлгуулах, сурталчлах ажлыг зохион байгуулах;</p> <p>2.13. 4.8. ногоочдыг сайн дураараа зохион байгуулалтад оруулж, ургацаа төв суурин газарт борлуулах ажлыг мэргэжлийн холбоодын оролцоотой зохион байгуулж, арга зүйн сургалт, сурталчилгаа хийх;</p> <p>3. “Хүнсний ногоо” үндэсний хөтөлбөрийн зорилт, арга хэмжээнээс хэрэгжээгүй буюу 0 үнэлгээтэй дараах арга хэмжээг эрчимжүүлэх, Үүнд:</p> <p>3.1. 2.2. Хүнсний ногоог ялгаж дугаарлах, сортлох, савлах төхөөрөмж, гар багажны хангамжийг сайжруулах;</p> <p>3.2. 4.6. усалтын систем, усалгааны тоног төхөөрөмжийн ашиглалт, таримлын ус хэрэглээ, технологийн талаар хүнсний ногоо тариалагчдад зориулсан сургалт зохион байгуулах, сурталчилгаа хийх;</p> <p>4. “Хүнсний ногоо” үндэсний хөтөлбөрийн төлөвлөгөөнд 2019 оноос хэрэгжүүлж эхлэхээр тусгагдсан 3 ажлыг амжилттай хэрэгжүүлэх чиглэлд анхаарах, холбогдох төрийн болон олон улсын байгууллагуудтай хамтран ажиллахыг тус тус зөвлөмж болгож байна.</p>				
8.	Төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэгч талуудын хамтын ажиллагаанд өгөх хөндлөнгийн үнэлгээ	Тус хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ холбогдох яамд, төрийн байгууллага, ТЭДС, дотоод, гадаадын төсөл, хөтөлбөрүүд, олон улсын байгууллагууд, төрийн бус байгууллагууд, хэвлэл, мэдээллийн байгууллагууд, аймгуудын ХХААГ, холбогдох эрдэм шинжилгээний байгууллагуудтай хамтран хөтөлбөрийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх талаар хангалттай сайн ажилласан гэж дүгнэж байна.				
9.	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлт	Биелэлт дундаж	Зорилт 1	Зорилт 2	Зорилт 3	Зорилт 4
	Хяналт-шинжилгээ, үнэлгээ (Зорилт, арга хэмжээний үнэлгээ)	66.4	66.2	45.4	85.0	68.8
10.	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн нэгдсэн үнэлгээ (ЗГХЭГ-ын үнэлгээ)	Нэгдсэн үнэлгээ				
		... %				